

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨТӨЧ НОМ



БАЯНХОНГОР

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Баянхонгор аймаг нь 1941 онд байгуулагдсан. Анх Говьбөмбөгөр гэж нэрлэгдэж байгаад дараахан нь Баянхонгор болж өөрчлөгдсөн.

Аймгийн төв: Баянхонгор хот
Хэдэн сумтай: 20
Нутаг дэвсгэрийн хэмжээ: 115,977.8 км²
Хүн ам: 84,807 (2016 он)
Угсаатан: Халх
Малын тоо толгой: 1963000
Утасны код: +976 (0)144
Шуудангийн дугаар: 64000
ТХ-ийн улсын дугаар: БНА
Цахим хуудас: www.bayankhongor.mn

Монгол улсын төвд орших бөгөөд аймгийн төв нь Улаанбаатараас 630 километр зайтай оршино. Их нуурын хотгорын дундад хэсэг, Алтайн цаад говийн нилээд нутгийг хамардаг. Нутгийн ихэнх нь далайн төвшнөөс дээш 1000-1400 метр өргөгдсөн. Хамгийн өндөр нь Их Богд уул 3957метр, хамгийн нам дор газар нь Эхийн гол 750 метр болно. Хар ус, Шар ус, Буянт, Хуримт, Сүмбэр, Заг, Байдраг, Түй, Шаргалжуут, Лиг, Цагаан гол, Баянцагаан зэрэг том, жижиг 160 гаруй гол горхитой. Бөөнцагаан, Орог, Адгийн цагаан, Дуут, Хуримт, Бөөрөг, Олгой зэрэг 30 шахам нуур бий. Шаргалжуут, Өргөөт, Тээл, Халиут, Ичээт, Хүрэн хад зэрэг халуун, хүйтэн 20 гаруй рашаантай. Эхийн гол, Шар хулстай, Цагаан бургас, Хуцын шанд, Өлзийт гол, Бурхант, Бор овооны задгай, баруун зүүн Тоорой зэрэг үзэсгэлэнт Баянбүрдүүдтэй.дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.



БАЯНХОНГОР

ХОТЫН ТУХАЙ



Хот болгосон нь: 1957 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 115 дугаар зарлигаар аймгийн төвийг Баянхонгор хот гэж нэрлэжээ. Баянхонгор сум нь “Номгон” уулын ар хормой, Түйн голын хөвөөнд суурьшсан, 5.8 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, тал хээрийн бүсийн элсэрхэг хөрстэй, далайн түвшнээс дээш 1845 метрийн өндөрт оршдог.

Өрхийн тоо: 8764

Хүн амын тоо: 30,931 (2017)

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 630 км



БАЯНХОНГОР АЙМГИЙН

БАЯНХОНГОР – ХҮН ҮҮСЛИЙН ӨЛГИЙ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОЛБОО

Аялал жуулчлалын холбоо 2013 онд байгуулагдан өдгөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулсаар байгаа билээ. Тус холбооны тэргүүнээр М.Батбаяр, нарийн бичгийн дарга Д.Сугармаа нар үүрэг гүйцэтгэж байна.

Холбоо барих утас: “Баянхонгор – Хүн үүслийн өлгий” НҮТББ, Баянхонгор аймгийн аялал жуулчлалын холбооны тэргүүн М.Батбаяр: 99001139, Нарийн бичгийн дарга Д.Сугармаа: 89668886.

БАЯНХОНГОР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

1-р маршрут

/Байгаль, түүхийн аяллын төрөлд хамаарна/

Чиглэл нь:

Баянхонгор хот-Цагаан цахир-Байдрагийн гүүр-Гурван мандал-Харлиутын рашаан-Хүрэн бэлчир-Гурван булаг-Хөх нуур-Биндэрьяа хөх нуур-Номун хааны хийд-Өхэг р а ш а а н - Ө р г ө ө т и й н рашаан-Үүдийн давс-Банхонгор хот

2-р маршрут

/Байгаль, сувилалын аялал/

Чиглэл нь:

Баянхонгор аймгийн хангайн чиглэлийн аяллын маршрут Баянхонгор хот-Шатарчулуу хөшөө-Эрдэнэ цогт сум-Өвгөн жаргалант зуслан-Тамчийн буган чулуу-Тамчийн хавцал-Эрхтийн х а в ц а л - Ш а р г а л ж у у т ы н рашаан-Бага Шаргалжуут рашаан-Бийрийн нуруу-Уушгийн хад-Өлзийт-Баянхонгор хот

3-р маршрут

/Байгаль, түүх соёл, палентлогийн аяллын төрөл/

Чиглэл нь:

Баянхонгор хот-Цагаан цахир-Шинэ жинст-Цагаан хаалга-Зуун мод-Дөш уул-Ногоон цав-Хаан тоорой мод-Эхийн гол-Сэгс цагаан богд-Хөөтийн агуй-Хатан суудлын хавцал-Цагаан бургас-Шар хулс-Амарбуянт хийд-Бозоо зааний чулуу-Баян Өндөр-Баян цагаан- Бөөн цагаан нуур-Баа цагаан нуур-Монгол бөхийн овоо-Цагаан цахир-Баянхонгор

4-р маршрут

/түүх, соёл, шашин мөргөлийн аялал/

Чиглэл нь:

Баянхонгор хот-Өлзийт-Бор балгас-Ээж хад-Хавцгайн х ө н д и й - Х о л б о о л ж нуур-Богд-Орог нуур-Монголын хоолой-Цагаан агуй-Хөөврийн гол-Баянлиг-Бичигт хад-Цагаан булаг-Баянговь-Их богд уул-Элсэн уул-Уран хайрхан-Баянхонгор хот

ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ЦАГААН АГУЙ

Цагаан агуй нь Баянхонгор аймгийн нутаг Бага Богд уулын өмнөд хэсэгт Баянлиг сумаас зүүн хойд зүгт 40 км зайтай, оршино. Уг агуй цул шохойн чулуун уулын бэлд шохойн чулуун уулыг хөндлөн огтолсон гүн хавцалд баруун тийш харсан 3.5метр өргөн, 3.2 метр өндөр амтай. Агуйн нийт урт 44.1 метр, 4.5 метр дундаж өндөртэй, 4.4 метр дундаж өргөнтэй. Хоорондоо нарийн хонгилоор холбогдсон дөрвөн том танхимтай. Эхний хонгил нь 8.0х9.6 метр хэмжээтэй бөгөөд дараагийн танхимуудын хэмжээ 2.0-3.0 метрээр буурдаг юм.

Агуй үүссэн чулуу нь венд кембрийн үеийн настай антигжсан шохойн чулуу юм. Уг агуй нь хэвтээ шинжийн карстын агуй юм. Агуйн хана дээврийн хэсэгт үүссэн ан цав маш бага, ургуу бана, унжуу бана ерөөсөө байхгүй. Гуравдах танхимд нилээд том яндан хоолой үүссэн бий.

Агуйн хана дээврийн хэсэг нь том том талстай шаравтар өнгөтэй исланд жоншны талстаар бүрхэгдсэн байна. Агуйн дээвэр нь бөмбөгөр хэлбэртэй, танхимуудын шал нь тэгш хавтгай юм. Агуйн эхний танхимд 9.0 метр урт, 3.2 метр өндөр, 3.5 метр өргөн хонгилоор дамжин орох бөгөөд энэ танхим саруул уужим юм. Танхимын дээврийн хэсэгт тооно хэлбэрийн том онгорхой бий. Агуйн гэрэлтэй бүс, адаад шилжилтийн бүс нилээд их юм.



ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

БИЧИГТ ХАД

Баянгийн нурууны Их Бичигтийн аманд эдүгээгээс 3000 жилийн тэртээд холбогдох эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох сүг зургууд бүхий байгалийн галарей бий. Энд сонирхол татсан нэгэн зураг бол анжисанд үхэр хөллөөд газар хагалж буй хүнийг дүрсэлсэн зураг.

Энэ зургийг МЭӨ-III мянган жилийн өмнөх үеийн бүтээл гэж үздэг. Үүнээс үзэхэд энэ нутагт оршин суугчид 3000 жилийн өмнө малын хүчийг тэргэнд хөллөн ашиглаж газар тариалан эрхлэж байсны нотолгоо юм. Иймээс энэ зураг нь Дэлхий дээр хамгийн анх түрүүн тэрэг бүтээсэн ард түмний нэг нь Монгол гэдгийг харуулж байгаагийн илэрхийлэл гэж нэгэн судлаач хэлсэн байдаг ба тоо хэмжээ, илэрхийлсэн сэдэв, зохиомж, дүрслэлийн арга барил, уран сайхан урлагийн бүхий л шинж чанараараа төв болон дундад азийн хадны сүг зургуудын дотор тэргүүн зэрэгт орох түүхийн хосгүй дурсгал юм.



ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ШАТАР ЧУЛУУН ХӨШӨӨ

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт байдаг “Шатар чулуу”-ны хөшөө дурсгал нь манай эриний өмнөх 3000 жилийн тэртээх эртний хүмүүсийн оюуны соёлын гайхамшигт өв юм.

Шатар чулууны хөшөө дурсгалын цогцолбор нь буган чулуун хөшөө гадуураа сийлбэр хээтэй, дөрвөлжин чулуун хашлагатай оруулга, монгол шатрын дүрс сийлбэрүүд байж болох янз бүрийн хэлбэрүүд, хиргисүүрүүдээс бүрдэнэ. Үүнтэй холбоотой “Монгол овогтны нэгэн том шатарчин хааныг нас барахад энд нутаглуулж, дурсгалыг нь мөнхлөн Шатар чулуун хөшөөг босгосон” гэх ам дамжсан домог бий. Олон хөшөө хиргисүүрээс бүрдсэн уг газрыг гадаад, дотоодын олон эрдэмтэн судлаад “Шатар Монголоос үүссэний баталгаа байж болох юм” гэж үзжээ.

Энэ мэтийн 50 гаруй дурсгал байдаг. Эдгээрийн олонхи болох буган чулуун хөшөөний оройн хэсэгт нь нарыг дүрсэлж хөшөөний эх биеийг хэд хэдэн бугыг загварчлан дүрслэх сонгодог аргаар болон бодит байдлаар урласан ба түүний доогуур нь бүс татаж зэр зэвсэг, чинжаал хутга, толь зэргийг дүрсэлсэн байна.

Барагцаалбал 13 буган чулуун хөшөө байгаа.



Photo By Erdenebulgan .B

ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ИХ БОГД УУЛ

Говь-Алтайн нурууны ноён оргилуудын нэг, мөнх цаст Их Богд уул нь далайн түвшнээс дээш 3957 метр өргөгдсөн, Монголын их говьд орших атлаа хангайн байгалийг санагдуулам номин ногоон хөвд ургамал, өнгө алаглах цэцэгсийн хүрээлэн, хүрхрэн шуугих өндөр уулын түргэн урсгалт гол горхи, газар хөдлөлтөөс тогтсон байгалийн өвөрмөц сонин тогтоц, нуур, дэлхийд ховордож дархлагдсан аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтад, вансэмбэрүү, алтангагнуур, лидэр зэрэг эмийн ургамлуудыг үзэж болох юм.

Их Богд уулын оргилд зуны дунд сард цас будран орж байхад уулын дунд хэсэгт бороо орж, бэл хоолойд нь 20-30 хэмийн халуун байдаг олон бичил уур амьсгалтай нутаг юм. Их Богд ууланд 1957 онд хүчтэй газар хөдлөлт болж уулын нэгэн оргил тасран унаж хоёр голын хөндийг хааснаар эдүгээ “Хөх нуур”, “Ногоон нуур” нэртэй үзэсгэлэнт хоёр нуурыг бий болгосон нь гадаадын жуулчдын сонирхлыг гойд татдаг билээ. Ууланд аялах дуртай аялагчдын сонирхлыг татдаг бүс нутгийн нэг нь их Богд уул юм. Их говийн дархан газар, байгалийн сонин тогтоц олонтой. Их Богд уул, Ичээтэй жарангийн нуруу, Өлзийт, Ноён, Тариат, Бургалтай зэрэг хараа булаам үзэсгэлэнт сайхан уулсаар чимэглэгдсэн болно. Хулан, хавтгай, аргаль, янгир, тэр ч байтугай Монголын улаан номд бичигдсэн олон олон ан амьтад бий.



ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ГАЛУУТЫН ХАВЦАЛ

Нутгийн хүмүүсийн домог яриагаар одоогоос 200-аад жилийн өмнө "Тоть" нуурын ус Галуутын хавцал үүссэн хотгороор ганцхан шөнө их дуу чимээ гарган нүүж одсон гэгдэх энэ хавцал нь гадаад дотоодын хүмүүсийн очих дуртай газрын нэг билээ.

Галуутын хавцал нь дунджаар 200-400 метр гүн, 50-200 метр өргөн, эрс цавчим хажуу ханатай, хамгийн нарийн газраа дөнгөж 2-3 метр өргөн хадан боом болж ирсэн тэр хэсэгт ялангуяа гол ус үертэй үед хүчтэй сүрлэг хүрхрээ боргио үүснэ.



ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ШАРГАЛЖУУТЫН ХАЛУУН РАШААН

Шаргалжуутын рашаан нь Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт далайн түвшнээс дээш 1500 метрт Улаанбаатар хотоос 670 орчим километр зайтай оршдог.

Шаргалжуутын гол руу түрж орсон Хатад хэмээх толгойн энгэрт байх боржин чулуунууд дундаас оргилон урсах 108 рашаан бий. Тэдгээр рашаанууд нь манай орны 50 гаруй халуун рашааны дотроос хамгийн халуун, хамгийн их нөөц ундаргатай нь юм. Ихэнхи ундарга нь 60-93 хэмийн халуун, хүхэрлэг, шаварлаг байдаг учраас эмчилгээнд ч хэрэглэдэг.

Шаргалжуут хэмээх нэрний учир нь Манжийн дарлалын үед элч нар Ховд, Улиастай ороод буцах замдаа “Их гол” хэмээх голыг гаталдаг байжээ. Нэгэн удаа Манжийн яаралтай мэдээ авч явсан элчийг ирэхэд “Их гол”-ын ус улаанаараа эргэлдэн хөөсөрч байжээ. Үүнээс үүдэн манжууд уг голыг “Шаргалжуутын гол” хэмээн нэрийдсэн байна. Нутгийнхан голынхоо нэрийг муухайгаар дуудуулахгүйн тулд “Шаргалжуут” хэмээн зөөллөжээ.

Энэхүү рашаан нь хэдэн зууны тэртээгээс анагаан эдгээх чадвараараа гайхагдаж, өвчиндөө шаналсан олон ардыг “тэнхрүүлэн тэтгэсэн буянт ус” билээ. Рашааны тогтоц нь, алгаа дэлгээд бүх эрхтэн, махбодь, эд эсээ дэлгэн хэвтэж байгаа хүний хэлбэртэй. Баянхонгор аймаг Шаргалжуутын рашаанаараа нэн алдартай. Тус рашаанд дотоод, гадаадын олон жуулчин, мөн өвчнөө анагаах, амарч сувилуулах хүсэлдээ хөтлөгдсөн олны хөл татарна гэж үгүй.



ҮЗМЭРҮҮД

БАЯНХОНГОР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ХОЛБООЛЖ НУУР

Баянхонгор хотоос зүүн өмнө зүгт 100 км зайд орших Холбоолжийн ягаан давс хэмээн алдарсан Холбоолж нуур нь хүнсний давсны томоохон орд газрын нэг бөгөөд эрт дээр үеэс хүмүүс давсанд орж, шавар эмчилгээ хийдэг ард эмчилгээний томоохон түшиц газрын нэг юм. Мөн давст нуурын зэрэгцээ орших нуурт төрөл бүрийн усны шувууд, тэдний дотроос хайр дурлалын бэлэгдэл хэмээн нэрлэдэг хун шувууд ихээр цуглардаг учир нутгийн иргэд энэ нуурыг Хунт нуур хэмээн нэрлэдэг юм.



БУСАД ҮЗМЭРҮҮД



БИНДЭРЪЯА ХӨХ НУУР

Баянхонгор аймгийн Жаргалант сумын нутагт байх энэхүү нуур байгалийн гайхамшигтай өвөрмөц тогтоцтой. Уулсаар хүрээлэгдсэн биндэръяа хөх өнгөтэй энэхүү нуур дээд зэргийн цэнгэг ус, олон төрлийн усны шувуудаараа алдартай. Олон зууны тэртээгээс түүх шаширт бичигдэж ирсэн энэхүү нуурыг сүүлийн жилүүдэд зорьж очигсод олон болжээ.

ЭРХЭТ, ТАМЧИЙН ХАВЦАЛ

Эрдэнэцогт сумын нутаг Тамчийн талд хүрэн толгойгоос доош 20 шахам км зайд эртний их хагарал галт уулын хүрмэн чулууг уулын голын ус зүссэнээс үүссэн маш сүрлэг гүн хавцал юм. Хананы өндөр хэдэн зуун метр хүрэх тул өвлийн улиралд ёроолд нар үл тусна. Мөн Гивэн, Халиут гэсэн хоёрхон оруулга замаар ердийн хөсгөөр нэвтрэхээс өөр гарцгүй, хүрмэн чулуу, хад асга болсон, хажуу хана дагаж хар мод ургаж, хавцлын дундуур боргио хөөсрөн урсах голын усны сав дагуу бургас, улиас, буриагуул, торлог эмжиж, арц бамбай зэрэг үнэртэн, сонгино, хад, тошлой, нохойн хошуу, алтан гагнуур, биелэг өвс зэрэг эмийн өвс ургамал ургасан байна. Ирвэс, шилүүс, буга согоо, бор гөрөөс, янгир, гахай, зэрэг ан амьтан байхаас гадна нүүдлийн ба суурин шувууд шивээлж цугласан байх юм.

ТҮРЭГИЙН ҮЕИЙН БИЧЭЭС

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт сумын төвөөс зүүн хойш 40 гаруй км-т орших баруун хойноос зүүн урагш цувран тогтсон оройг нь тэгш тайрсан мэт сонин тогтвортой гурван уулыг Гурван мандал хэмээнэ. Энд хадны зураг, эртний Түрэгийн рупи бичээс тэргүүтэй сонирхолтой дурсгал тун ихтэй. Ялангуяа уулын оройн тэгш толигор хаднуудаар олон үеийн хүний бүтээл, хадны сүг зураг, тамга тэмдгийн зүйл арвин ажээ.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД

БАЯНХОНГОР ХОТЫН ЗОЧИД БУУДАЛ



БУЯНТ БОГД ӨРГӨӨ

📍 Баянхонгор аймгийн
Баянхонгор сум

☎ 70440080 88445091

🌐 facebook.com
/Буянт-Богд-Өргөө-Urguu-Hotel/

📄 lounge.resistors.showroom



ӨЛЗИЙТ ПАЛАС

📍 Баянхонгор аймгийн
Баянхонгор сум

☎ 77440011 99112346

🌐 facebook.com/BayankhongorUlziitPalace/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



СОЁМБО

📍 Баянхонгор аймгийн
Баянхонгор сум

☎ 70444599 88112176

🌐 facebook.com/soyombohotel/

📄 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

САРЛАГИЙН НААДАМ

Сарлагийн тоо толгойг хамгаалах, нэмэгдүүлэн өсгөж үржүүлэх, сарлагийн ашиг шим, тэдгээрийн бүтээгдэхүүнийг сурталчлах зорилготой.

ХУГАЦАА:

Жил бүрийн 08 дугаар сард

ХААНА:

Баянхонгор аймаг, Эрдэнэцогт сумын төв

ХӨТӨЛБӨР:

- Сарлаг унасан сайхан хос шалгаруулах тэмцээн
- Ердийн хөсгийн цуваа
- Уран бугуйлч шалгаруулах тэмцээн
- Сарлаг үхрийн уралдаан
- Сайхан бух шалгаруулах тэмцээн
- Эмнэг сарлаг булгиулах тэмцээн
- Сарлагийн гаралтай сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал бэлэг дурсгалын үйлчилгээ

Утас: 70444436, 86224024,
88205556



ТҮЙН ГОЛЫН ЖАВАР ӨВЛИЙН НААДАМ

Өнөтэй сайхан өвөлжихийн бэлэг тэмдэг өвлийн наадам.

ХУГАЦАА:

Жил бүрийн 02 дугаар сард

ХААНА:

Баянхонгор сум, Түйн гол

ХӨТӨЛБӨР:

- Мөсөн шагайн тэмцээн
- Шагай шүүрэх, няслах тэмцээн
- Хээрийн цайны амт шалгаруулах тэмцээн
- Үндэсний хувцастай сайхан хос шалгаруулах тэмцээн
- Эрэгтэй, эмэгтэй цанын уралдаан
- Өвлийн үндэсний хувцасны худалдаа

Утас:70444436, 86224024

